# УЛААНБААТАР
## ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
# ТОГТООЛ

1980 оны 7 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 214 | Улаанбаатар хот

Хотын АДХГЗ-ны 1989 оны 161 р тогтоол

**ХҮҮХДИЙН ХЭСГИЙН ЭМНЭЛЭГ НЭМЖ АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ**

Улаанбаатар хотын намын хорооны 4-р бүгд хурлын шийдвэр болон БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 173-р тогтоолын I-ийн "б" заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ НЬ:

I.Нялхсын өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх ажлыг хүчтэй болгох зориудын арга хэмжээгээр БНМАУ-ын Эрүүлийг Хамгаалах Яамнаас 40 эмч хуваарилан ирүүлсэнтэй холбогдуулж 7-р сарын I-нээс эхлэн Хүүхдийн хэсгийн эмнэлэг 20-ийг шинээр нэмэгдүүлэн ажиллуулсугай.

2.Дээрх 20 хэсгийн эмнэлгийг хотын эрүүлийг хамгаалах арга хэмжээнд 1980 онд батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлж, 1981 оноос эхлэн жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусган батлуулаж ажиллахыг хотын төлөвлөгөөний комисс /н.Сумаахүү/, санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/, эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ